

## **ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ТҮМЭН ШУВУУТ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД**

### **Санхүүгийн Тайлангийн Аудитын Тайлан**

#### **Дүгнэлт**

Бид, ТҮМЭН ШУВУУТ ХК-ийн (цаашид Компани гэх) 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх тусдаа санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх тусдаа орлогын дэлгэрэнгүй тайлан, тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан, тусдаа мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан тусдаа санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн тусдаа санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан тусдаа санхүүгийн тайлангууд нь Компанийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээ нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулагдсан байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

## **Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант жилийн тусдаа санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн их ач холбогдолтой, нөлөө бүхий асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй. Бид дараах асуудлыг гол асуудал гэж тодорхойлсон.

### *Зээлийн хүүгийн зардалтай холбоотой*

Компани нь тайлант үед 606,625 мянган төгрөгийн зээлийн хүүг хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд тусгасан байгаа бөгөөд үүнээс 504,013 мянган төгрөгийн хүүг үйлдвэрлэсэн өндөг болон тэжээлийн өртөгт шингээсэн байна (Тодруулга 12, 25, 31).

НББОУС 23 Зээлийн өртөг стандартын 7-р заалтын дагуу богино хугацаанд их хэмжээгээр үйлдвэрлэн бэлэн болгодог бараа материалыг шалгуур хангах хөрөнгө гэж үзэхгүй ба шалгуур хангаагүй хөрөнгийн өртөгт зээлийн хүүгийн зардлыг шингээхгүй байх нь зүйтэй.

Уг асуудалтай холбоотой материаллаг буруу илэрхийлэл үүсээгүй гэж үзсэн тул аудитын дүгнэлтэд өөрчлөлт ороогүй.

## **Асуудлыг онцгойлсон зүйл**

Бидний аудитлагдсан санхүүгийн тайлангийн Тодруулга 37-д ОХУ-ын Засгийн газраас 3 дугаар сарын 14-нд экспортын хориг тавих тогтоолыг баталсантай холбоотой асуудлын компанид үзүүлэх үр нөлөөг тодорхойлон түүнд анхаарлаа хандуулж байна. Энэ асуудлын улмаас бид дүгнэлтээ өөрчлөөгүй.

Компани нь 2022 оны 1 сарын 26-ны өдрийн ТУЗ-ын тогтоолоор тайлант үеийн цэвэр ашгийн 30 хувь буюу нэгж хувьцаанд 10.4 төгрөгийн, нийт 2,080,000 мянган төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн.

## **Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр тусдаа санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй тусдаа санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.



Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

### **Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Бидний зорилго санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргахад байдаг. Үндэслэлтэй нотолгоо нь баталгааны өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг цаг ямагт илрүүлж байна гэсэн амлалт өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилангаас эсвэл алдаанаас үүсэж болох ба дангаараа нийлээд материаллаг болж эдгээр алдаа нь санхүүгийн тайлангууд дээр суурилан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай гэж үзсэн үед материаллаг буруу илэрхийллийг авч үзнэ.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн үнэлэмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримталдаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.

- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын хийсэн тооцоолол болон холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл харуул хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг.

Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үздэг учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.



## **Бусад мэдээлэл**

Удирдлага нь бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Аудитын дүгнэлт нь бусад мэдээллийг хамруулаагүй буюу бид үүнтэй холбоотой ямар нэгэн баталгаажуулалт хийгээгүй болно.

Бидний гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээлэлтэй уншиж танилцан, бусад мэдээлэл нь аудитлагдсан санхүүгийн тайлан болон аудитын явцад олж авсан аудиторын мэдлэгээс материаллаг зөрүүтэй эсэхийг тодорхойлох үүрэгтэй. Хэрэв бусад мэдээлэл нь материаллаг зөрүүтэй бол бид энэ тухай тайлагнах үүрэгтэй.

Түмэн Шувуут ХК-ийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой үйл ажиллагааны тайлангийн санхүүгийн мэдээллүүд нь бидний аудитлагдсан дүнгээс материаллаг зөрүүгүй байна. Тиймээс бусад мэдээллийн талаар тайлагнах зүйлс байхгүй.

## **Бусад асуудлууд**

### *Тайлангийн хэрэглэгчид*

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Түмэн Шувуут ХК-ийн Монгол улсын Компанийн тухай хуулийн 4-р зүйлд заасан хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан бөгөөд бусад этгээдэд зориулагдаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

### *Сонирхлын зөрчилтэй хэлцэл*

Компани нь тайлант жилд Компанийн тухай хуулийн 89.1 заалтад тусгасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй.

### *Их хэмжээний хэлцэл*

Компани нь тайлант жилд Компанийн тухай хуулийн 87.1 заалтад тусгасан их хэмжээний хэлцэл хийгээгүй.

### *Тусдаа санхүүгийн тайлан*

Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8-р зүйлд заасны дагуу охин компанийг хамруулан нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх үүрэгтэй бөгөөд энэхүү санхүүгийн тайланг удирдлага болон бидний хооронд гэрээний дагуу *НББОУС 27 Тусдаа санхүүгийн тайлангууд* стандартын дагуу бэлтгэсэн (Тодруулга 3).

Эхний үлдэгдэл

Компанийн 2020 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон тусдаа санхүүгийн тайланг Грант Торнтон Аудит ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд стандарт дүгнэлт өгсөн байна.



МЭРГЭЖЛИЙН ҮЙДЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Н.МЯГМАРЖАВ

Огноо: 2022.04.20

Хаяг: Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 7/3,  
байр, Centrum төв, 7 давхар 701 тоот.

Утас: +976 7015 0003;

И-мэйл: [info@moore-mongolia.mn](mailto:info@moore-mongolia.mn)

**ТҮМЭН ШУВУУТ ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТУСДАА ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН  
2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	Тодруулга	АУДИТЛАГДСАН	АУДИТЛАГДСАН
		2021.12.31 Мян.төг	2020.12.31 Мян.төг
Гэрээний орлого	7	35,912,919	25,393,262
Борлуулалтын өртөг	8	(32,918,823)	(23,918,959)
<b>Нийт ашиг</b>		<b>2,994,096</b>	<b>1,474,303</b>
Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бодит үнэ цэнийн олз	9	8,134,243	5,779,570
Ерөнхий удирдлагын зардал	10	(1,234,643)	(1,444,530)
Борлуулалт маркетингийн зардал	11	(1,974,991)	(1,412,877)
<b>Үндсэн үйл ажиллагааны (алдагдал)</b>		<b>7,918,705</b>	<b>4,396,466</b>
Санхүүгийн орлого (зардал)	12	(3,051)	(69,556)
Бусад орлого	13	95,962	272,380
Бусад зардал	14	(111,790)	(129,073)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	15	(12,332)	(6,025)
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>7,887,494</b>	<b>4,464,192</b>
Орлогын татварын зардал	16	(1,004,323)	(452,668)
<b>Тайлант жилийн цэвэр ашиг (алдагдал)</b>		<b>6,883,171</b>	<b>4,011,524</b>
Бусад дэлгэрэнгүй ашиг		-	-
<b>Нийт дэлгэрэнгүй ашиг (алдагдал)</b>		<b>6,883,171</b>	<b>4,011,524</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг, төгрөгөөр</b>		<b>34.42</b>	<b>20.06</b>

Тусдаа санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**ТҮМЭН ШУВУУТ ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТУСДАА САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН  
2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	Тодруулга	АУДИТЛАГДСАН	АУДИТЛАГДСАН
		2021.12.31 Мян.төг	2020.12.31 Мян.төг
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө ба дуусаагүй барилга, байгууламж	17	22,972,024	18,432,596
Биет бус хөрөнгө	18	394,090	425,758
Эргэлтийн бус биологийн хөрөнгө	19	1,955,250	1,969,423
Эргэлтийн бус бусад авлага	20	4,630,567	1,790,768
Урт хугацаат хөрөнгө оруулалт	21	814,565	876,885
<b>Нийт бус эргэлтийн хөрөнгө</b>		<b>30,766,496</b>	<b>23,495,430</b>
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Эргэлтийн биологийн хөрөнгө	22	1,093,087	480,289
Урьдчилж төлсөн төлбөр	23	2,636,337	2,121,840
Бусад авлага	23	91,935	-
Татвар, шимтгэлийн авлага	24	437,722	-
Бараа материал	25	7,646,299	3,519,048
Худалдааны авлага	26	1,449,513	3,155,198
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	27	3,347,026	1,170,984
<b>Нийт эргэлтийн хөрөнгө</b>		<b>16,701,919</b>	<b>10,447,359</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>47,468,415</b>	<b>33,942,789</b>
<b>ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР</b>			
<b>Эздийн өмч</b>			
Энгийн хувьцаа	28	4,000,000	4,000,000
Нэмж төлөгдсөн капитал	29	8,007,687	8,007,687
Хуримтлагдсан ашиг	30	19,802,798	13,202,523
<b>Нийт өмч</b>		<b>31,810,485</b>	<b>25,210,210</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Урт хугацаат зээл	31	8,017,308	1,550,000
<b>Нийт урт хугацаат өр төлбөр</b>		<b>8,017,308</b>	<b>1,550,000</b>

Тусдаа санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**ТҮМЭН ШУВУУТ ХУВЬЦААТ КОМПАНИ**  
**ТУСДАА САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**  
**2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	Тодруулга	АУДИТЛАГДСАН	АУДИТЛАГДСАН
		2021.12.31	2020.12.31
		Мян.төг	Мян.төг
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Худалдааны өглөг	32	821,956	631,402
Орлогын татварын өр төлбөр	33	575,284	243,553
Бусад татварын өр төлбөр	33	398,219	376,354
Бусад өглөг	34	375,177	1,923,252
Гэрээний өр төлбөр	34	17,865	8,747
Нөөц өр төлбөр	35	246,579	158,879
Богино хугацаат зээл	31	5,150,762	3,800,000
Зээлийн хүүгийн өр төлбөр	31	54,780	40,392
<b>Нийт богино хугацаат өр төлбөр</b>		<b>7,640,622</b>	<b>7,182,579</b>
<b>Нийт өр төлбөр</b>		<b>15,657,930</b>	<b>8,732,579</b>
<b>НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР</b>		<b>47,468,415</b>	<b>33,942,789</b>

Тусдаа санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ТҮМЭН ШУВУУТ ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТУСДАА ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН  
2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	Энгийн хувьцаа Мян.төг	Нэмж төлөгдсөн капитал Мян.төг	Эздийн өмчийн бусад хэсэг Мян.төг	Хуримтлагдсан ашиг Мян.төг	Дүн Мян.төг
<b>2019.12.31-ний аудитлагдсан үлдэгдэл</b>	<b>4,000,000</b>	<b>8,007,687</b>	<b>101,838</b>	<b>10,911,575</b>	<b>23,021,100</b>
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	(101,838)	(120,576)	(222,414)
Зарласан ногдол ашиг	-	-	-	(1,600,000)	(1,600,000)
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	4,011,524	4,011,524
Бусад дэлгэрэнгүй ашиг	-	-	-	-	-
<b>2020.12.31-ний аудитлагдсан үлдэгдэл</b>	<b>4,000,000</b>	<b>8,007,687</b>	<b>-</b>	<b>13,202,523</b>	<b>25,210,210</b>
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	(240,000)	(240,000)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(42,896)	(42,896)
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	6,883,171	6,883,171
Бусад дэлгэрэнгүй ашиг	-	-	-	-	-
<b>2021.12.31-ний аудитлагдсан үлдэгдэл</b>	<b>4,000,000</b>	<b>8,007,687</b>	<b>-</b>	<b>19,802,798</b>	<b>31,810,485</b>



Тусдаа санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**ТҮМЭН ШУВУУТ ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТУСДАА МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	<b>АУДИТЛАГДСАН 2021.12.31 Мян.төг</b>	<b>АУДИТЛАГДСАН 2020.12.31 Мян.төг</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Татварын өмнөх ашиг (алдагдал)	<b>7,887,494</b>	<b>4,464,192</b>
<i>Тохируулга:</i>		
Үндсэн хөрөнгийн элэгдэл	1,625,468	1,322,202
Биет бус хөрөнгийн хорогдол	31,668	4,260
Биологийн хөрөнгийн элэгдэл	2,903,317	2,646,896
Биологийн хөрөнгөтэй холбоотой үүссэн (олз) гарз	22,880	826,217
Санхүүгийн зардал (орлого)	606,040	69,556
Валютын ханшийн зөрүүний бодит бус (олз) гарз, цэвэр	(7,856)	(2,990)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны (олз) гарз	13,644	212,612
Өмнөх үеийн хуримтлагдсан ашигт оруулсан залруулгын нөлөөлөл	(42,896)	-
<i>Тохируулгын дараах татварын өмнөх ашиг</i>	<b>13,039,759</b>	<b>9,542,945</b>
<i>Ажлын капиталын өөрчлөлт:</i>		
Худалдааны өглөгийн өсөлт /(бууралт)	190,554	879
Бусад өглөгийн өсөлт /(бууралт)	192,677	(249,294)
Худалдааны авлагын (өсөлт) /бууралт	1,705,685	(1,939,955)
Урьдчилж төлсөн зардал, бусад авлагын (өсөлт) /бууралт	(969,676)	1,253,636
Бараа материал (өсөлт)/бууралт	(4,127,251)	(2,048,838)
<i>Ажлын капиталын өөрчлөлтийн дараах татварын өмнөх ашиг</i>	<b>10,031,748</b>	<b>6,559,373</b>
Орлогын албан татварт төлсөн	(769,138)	(420,705)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>9,262,610</b>	<b>6,138,668</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Хүлээн авсан хүүгийн орлого	-	1,883
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(6,331,519)	(3,720,060)
Үндсэн хөрөнгө борлуулснаас хүлээн авсан мөнгө	152,979	57,352
Биет бус хөрөнгө худалдан авалт	-	(418,155)
Биологийн хөрөнгө худалдан авалт	(3,524,822)	(4,117,159)
Охин компанид олгосон	(2,839,799)	-
Охин компаниас хүлээн авсан	62,320	949,866
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(12,480,841)</b>	<b>(7,246,273)</b>

Тусдаа санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ТҮМЭН ШУВУУТ ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТУСДАА МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	<b>АУДИТЛАГДСАН 2021.12.31 Мян.төг</b>	<b>АУДИТЛАГДСАН 2020.12.31 Мян.төг</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Хүлээн авсан зээл	12,500,000	5,000,000
Зээлийн үндсэн төлбөрт төлсөн	(4,681,930)	(4,450,000)
Зээлийн хүүд төлсөн	(591,653)	(31,047)
Сан нөөц өр төлбөрт хуримтлуулсан	(240,000)	(222,414)
Зарласан ногдол ашиг	-	-
Ногдол ашигт төлсөн	(1,600,000)	(916,173)
<b>Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>5,386,417</b>	<b>(619,634)</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт /(бууралт)</b>	<b>2,168,186</b>	<b>(1,727,239)</b>
Мөнгөн болон түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн зөрүүний олз /(гарз)	7,856	2,990
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,170,984</b>	<b>2,895,233</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>3,347,026</b>	<b>1,170,984</b>

Тусдаа санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**ТҮМЭН ШУВУУТ ХУВЬЦААТ КОМПАНИ**  
**2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТУСДАА**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАН**  
**ЗАСАГЛАХ ЭТГЭЭДИЙН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ**

Түмэн Шувуут ХК-ийн гүйцэтгэх удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу үнэн зөв, шударгаар илэрхийлэх үүрэгтэй.

Засаглах удирдлага нь Компанийн тухай хуулийн 81.4.1-д заасны дагуу компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг СТОУС-т нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү болон үйл ажиллагааны бусад мэдээллийн үнэн зөв бодит байдалд хяналт тавих үүрэгтэй.

Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журамд нийцүүлэн бэлтгэхэд хяналт тавьж ажилласнаа үүгээр мэдэгдэж байна.

Компанийн засаглал хариуцсан этгээдээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон тусдаа санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.



Огноо:

Ц.НАРАН-УЧРАЛ

АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА

Огноо:

**ТҮМЭН ШУВУУТ ХУВЬЦААТ КОМПАНИ**  
**2021 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТУСДАА**  
**САНХҮҮГИЙН ТАЙЛАН**  
**УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ**

---


Түмэн Шувуут ХК-ийн удирдлага бид санхүүгийн тайлангаа бэлтгэх явцад Хараат бус аудиторын тайлан дахь *Санхүүгийн тайлангийн аудитад удирдлагын хүлээх үүрэг хариуцлага* хэсэгт дурдсан үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрч байна гэдгийг мэдэгдэж байна.

Бид эдгээр тусдаа санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Компанийн удирдлагаас 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон тусдаа санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.

  
Ж.БОЛД  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Огноо:

  
Н.ДОЛЖИНСҮРЭН  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Огноо: